

Үйл ажиллагааны ТОВЧ ТАЙЛАН

...

April 2024



1. Удиртгал

Танилцуулга

“Стор пэй” ХХК нь Монголд 2019 онд иргэд болон бизнесийн байгууллагад тулгараад байсан төлбөрийн асуудлыг шийдэх зорилготойгоор үүсгэн байгуулагдсан ба Монголын хамгийн олон хэрэглэгч, харилцагчтай Buy Now, Pay Later буюу **“ОДОО АВААД, ДАРАА ТӨЛ”** финтекийн хуваан төлөх шийдлийн үйлчилгээ үзүүлэгч компани юм.

Бид хэрэглэгчиддээ хэрэглэхэд хялбар, тэгш хүртээмжтэй, цаг хугацаа хэмнэсэн Финтек, Криптовалют, Блокчейн технологиудын өвөрмөц хослол бүхий санхүүгийн таатай үйлчилгээг санал болгоод зогсохгүй харилцагч байгууллагын борлуулалтын аюулгүй, эрсдэлгүй сүвгийг бий болгох эрхэм зорилготой ажиллаж байна.


“Стор пэй” ХХК нь өөрсдийн дэд бүтцэд тулгуурлан “SPC” (Storepay Coin) шинэ криптовалютыг Монголын зах зээлд 2021 онд танилцуулсан. SPC нь Binance Smart Chain-д суурилсан BEP20 стандартын токен бөгөөд Монгол болон Азийн хэрэглэгчдэд блокчейнд суурилсан худалдан авалтын урамшууллын ухаалаг, өгөөжтэй шийдлийг санал болгосон бүтээгдэхүүн юм. Бид хэтэвч, үндсэн үйлчилгээнд ашиглах mining буюу буцаан олголт зэрэг SPC-ийн цогц экосистемийг бий болгохоор хөгжүүлэлтийн замналаа төлөвлөсөн ба Монголын зах зээлээс цар хүрээгээ Зүүн Өмнөд Азийн 676 сая хэрэглэгчтэй зах зээл рүү өөрсдийн үйлчилгээг тэлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2. Үндсэн үйл ажиллагаа

Хэрэглэгчийн тоон үзүүлэлт

Нийт Storepay-д бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 452,912 байгаагаас 62% нь эмэгтэй, 38% нь эрэгтэй хэрэглэгчид байна.

Хэрэглэгчдийг насны ангиллаар авч үзвэл:




Бүтээгдэхүүн үйлчилгээний тухай

Storepay нь ямар ч хүү, шимтгэл нэмэлт төлбөргүй хуваан төлөх нөхцөлтэй одоо аваад дараа төл (BNPL) үйлчилгээ юм. Storepay үйлчилгээ нь хэрэглэгч нарт худалдан авалтын таатай нөхцөлийг олгоод зогсохгүй харилцагч байгууллага, бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлж, тэлэхийг дэмжих зорилгоор гадаад болон дотоод худалдан авалтанд нь энэхүү хуваан төлөх үйлчилгээг ашиглах боломжийг олгож байгаагаараа онцлогтой. Storepay аппликейшн нь дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог.

Storepay үйлчилгээ

Storepay үйлчилгээний эрх хэрэглэгч нарт 100,000 – 10,000,000 төгрөгийн хооронд үүсэх бөгөөд хэрэглэгчийн анх үүссэн эрх нь худалдан авалт амжилттай төлж дуусах бүрт нэмэгдэх боломжтой. Хэрэглэгч Storepay аппликейшнд бүртгүүлэн хүсэлтээ илгээснээр үйлчилгээний эрхээ шүүд нээлгэн ашиглах боломжтой бөгөөд бичиг баримт бүрдүүлэх, салбар дээр ирэх шаардлагагүй юм. Storepay хэрэглэгчийн түвшин дараах хоёр төрөлтэй.

Storepay энгийн хэрэглэгч



Шинээр анх удаа хэрэглэгчээр орж ирсэн хэрэглэгчид тус ангилалд байдаг бөгөөд хэрэглэгч 45 хоногт 4 хуваан төлөх нөхцөлтэй 2 худалдан авалтыг амжилттай төлж дууссаны дараа дараагийн түвшин болох Premium хэрэглэгч болох боломжтой.


Premium хэрэглэгч



2 болон түүнээс дээш худалдан авалт амжилттай төлж дуусгасан Premium хэрэглэгчдэд 60 хоногт 3 хуваах, 2 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй (Дээд дүн 10 сая) худалдан авалтыг 4 сард 5 хуваан (эхний төлөлт орно) төлөх сонголтууд нэмэгдэнэ.

- Хуваан төлөх сонголтууд**
- 60 хоногт 3 хуваах
 - 60 хоногт 4 хуваах /Урьдчилгаагүй/
 - 4 сард 5 хуваах

SPC Wallet



SPC нь Storepay аппликейшний үйл ажиллагаатай уялдуулан гаргасан криптовалют юм. Энэхүү бүтээгдэхүүнийг ашигласнаар худалдан авалт бүрийн нийт үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх SPC токеныг урамшуулалд авах боломжтой. Худалдан авалтын урамшуулалд олгогдсон SPC нь SPC хэтэвчинд байрлах ба арилжааны биржүүдээс SPC-г худалдан авч өөрийн хэтэвчинд байршуулан худалдан авалтын эрхээ үүсгэх, эрхийн хэмжээг нэмэгдүүлэх болон идэвхтэй худалдан авалтад ашиглах боломжтой.

Storepay B2B




Хамтран ажилладаг мерчант байгууллагууддаа зориулан Storepay үйлчилгээгээр дамжуулан хийгдэж буй борлуулалтад үндэслэн "B2B мерчант" буюу 100 сая төгрөг хүртэл худалдан авалт хийх бизнес эрх нээх үйлчилгээг нэвтрүүлсэн. Бизнес эрхлэгчид болон байгууллагууд энэхүү эрхийг ашигласнаар байгууллагын хэрэгцээт худалдан авалтаа болон бараа бүтээгдэхүүн татан авахдаа хамгийн таатай, хамгийн хялбар, ямар ч хүү, шимтгэл, нэмэлт төлбөргүй хуваан төлөх нөхцөлөөр шийдэх боломжтой юм.

Storepay Auto



Storepay Auto үйлчилгээ нь 150 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий авто машин худалдан авахад зориулсан санхүүжилтийн үйлчилгээ юм. Хэрэглэгчид нь манайхтай хамтран ажиллах гэрээтэй дилер байгууллагуудаас авто машин худалдан авах бөгөөд тухайн газартаа очин гэрээгээ хийж хүсэлтээ илгээх юм.

Invoice Financing



2023 оны 11 сард бизнес эрхлэгчиддээ зориулан “B2B Invoice Financing” үйлчилгээг зориулан гаргалаа. Энэхүү үйлчилгээг авснаар бизнес эрхээ ашиглан гадаад худалдан авалт, импортын нэхэмжлэхээ хуваан төлөх боломжтой юм.

УРТААР



Хас банктэй хамтран гаргасан энэхүү “Уртаар” үйлчилгээ нь худалдан авсан бараа болон үйлчилгээний төлбөрийг 30 сарын хугацаанд 30 хуваан төлөх боломжийг олгосон үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээг ашиглахын тулд хэрэглэгч өөрийн биеэр ирэх шаардлагагүй, Монгол улсын өнцөг булан бүрээс Storepay аппликейшний УРТААР цэсэд нэвтэрч мэдээллээ оруулж, цахим гэрээ байгуулснаар 5 мин дотор Уртаар үйлчилгээний 30 хүртэлх сая төгрөгийн худалдан авалтын эрхийг үүсгэх боломжтой юм.


3. Санхүүгийн үзүүлэлт

Компани STOREPAY үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээс хойш 2023 оныг дуусталх хугацаанд гэрээт 4000 гаруй байгууллагын нийт 275.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг ОДОО АВААД ДАРАА ТӨЛ үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдэд борлуулсан байна.

Жилийн борлуулалт



Хэрэглэгч болон мерчантын тоо



SPC

SPC 149,471,731,912

Нийт SPC токен

SPC 376,875,196

SPC staking үйлчилгээний урамшуулалд олгосон

SPC 15,151,391,890

2022.01.01-2024.04.30 хооронд шатаасан SPC токен

SPC 435,000,000,000

Удирдлагын шийдвэрээр бусад сангаас шатаасан

Хураангуй үзүүлэлт

4.5 тэрбум ₮

Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын орлого

4,792+

Сторпэй үйлчилгээ боломжтой дэлгүүр, үйлчилгээний төв

516,685+

Бүртгэлтэй хэрэглэгчид

235,167+

Идэвхтэй хэрэглэгчид

15%+

Сторпэй үйлчилгээ нэвтрүүлснээр мерчантад бий болсон борлуулалтын өсөлт

1,092,336+

Нийт хийгдсэн худалдан авалтын тоо

2,554+

Сторпэй үйлчилгээгээр өдөрт хийгдэж буй худалдан авалтын тоо

372+ тэрбум ₮

Нийт худалдан авалтын дүн

34.05+ тэрбум ₮


Хэрэглэгчдэд үүсгэсэн хэмнэлт

Storepay үйлчилгээний хэрэглэгчид хугацаа хэтрэлгүй, амжилттай төлж дууссан худалдан авалтын үнийн дүнгийн 1%-тай тэнцэх хэмжээний SPC токеныг урамшуулал болгон олгож, тухайн урамшуулалд олгосон хэмжээгээр зах зээлээс SPC токеныг худалдан авч, шатаалт хийдэг байсан бол 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн урамшуулалд олгох токеныг 0.5%, худалдан авч шатаалт хийх токеныг үнийн дүнгийн 1% болгон өөрчлөх шийдвэр гаргасан болно.


Түүнчлэн өнгөрсөн онд Монгол улсад бүртгэлтэй ВХҮҮ биржүүд дээрх SPC токены ханш оны эхний хагастай харьцуулахад 47.3%¹ өсөлтийг үзүүлж, IEO хийх үеийн үнээс өсөлт үзүүлсэн цөөн хэдэн виртуал хөрөнгийн нэг болсон байна.

Нийт хөрөнгийн бүтэц

2022 он



2023 он



■ Эргэлтийн бус хөрөнгө
 ■ Хэрэглэгчдээс авах авлага
 ■ Бусад эргэлтийн хөрөнгө

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар нийт хөрөнгийн дүн 31.83 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 1.5 дахин өссөн. Энэхүү өсөлтөд BNPL үйлчилгээний өсөлттэй холбоотойгоор нэмэгдсэн дансны авлагын өсөлт голчлон нөлөөлсөн байна.

Харин борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

¹ ВХҮҮ-ийн салбарын үйл ажиллагааны нэгдсэн тайлан 2023, СЗХ

4. Эрсдэлийн удирдлага

МУТСТ-тэй тэмцэх үйл ажиллагаа

Стор пэй ХХК нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд ордоггүй боловч компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх үүднээс тус хуульд заасны дагуу 2023 оны 03 сарын 10-ны өдрийн А/03 дугаартай гүйцэтгэх захирлын тушаалаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журмыг баталсан.

Энэхүү журмыг компанийн нийт ажилтнуудад танилцуулах сургалт зохион байгуулж, бүх ажилчдыг хамруулах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн цаашлаад шинэ орсон ажилтнуудад заавал танилцуулах шаардлагатай журмын нэг хэсэг болгон ажиллаж байгаа болно.

Мэдээллийн аюулгүй байдал

Финтек компанийн хувьд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь учирч болох асар том эрсдэлээс хамгаалах маш чухал үйл ажиллагаа тул хүн, технологи, процесс гурвалсан холбоон дээр дараах арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлж байна.

1

Хөндлөнгийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ болон шалгалт

2023 оны 07 – 2023 оны 09 сар

Компанийн мэдээллийн аюулгүй байдлын процесс, хүн болон технологийн нөхцөл байдлыг тодорхойлох нэвтрэлтийн болон эрсдэлийн шалгалтыг хийлгэж тодорхойлогдсон эрсдэл, үл нийцэлд холбогдох арга хэмжээг авч ажилласан.

2

Технологи

2023 оны 07 – 2023 оны 12 сар

Халдлагаас хамгаалах веб аппликейшн галт хана (WAF) болон төгсгөлийн төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах шийдлийг нэвтрүүлэлтийг болзошгүй эрсдэлүүдийг бууруулан ажиллав.

3

Процесс

2023 оны 10 – 2023 оны 12 сар

Компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах “Мэдээллийн аюулгүй байдлын цогц бодлого” болон холбогдох журмыг баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж эхлэв.

4

Хүн


2023 оны 07 сараас хойш

Нийт ажилтнуудад мэдээллийн аюулгүй байдлын түгээмэл халдлага болон урьдчилан сэргийлэх ойлголт өгөх зөвлөмж болон сургалтыг зохион байгуулав. Цаашид тогтмол хугацаанд МАБ-ын сургалт, зөвлөмжийг нийт ажилтнуудад хүргэж ажиллах бодлогыг баримталж байна.

5. Бусад

Хүрээлэн буй орчны хүрээнд

Дорноговь аймагт хэрэгжиж буй “Шамбала2056 - Инженерийн суурин, Говийн ирээдүйг бүтээх нь 2.0 төсөл”-ийн “ART’N TECH Land Art” цөлжилтийг сааруулах моджуулах аянд нэгдэн Storepay-ийн нэрэмжит 100 ш Тарваган хайлаас /Ulmus pumila/модыг зайнаас тандан судлах мэдээлэл болон блокчэйн технологи дээр суурилсан модны ургалтыг бүрэн хянах боломжтой Treelings системийг бүтээсэн мэргэжлийн хамт олонтой хамтран 2023 оны 9 сард тариулж ургуулсан бөгөөд одоогийн байдлаар 1611 кг CO₂-ыг шүүсэн байна.



Мөн бид байгаль орчиндоо ээлтэй ажиллаж, амьдрахын ач холбогдлыг ажилтнууддаа ойлгуулах, мэдлэгийг тэлэх үүднээс тохирох сургалтуудыг авч, сурсан зүйлсээ бодит амьдрал дээр хэрэгжүүлэх боломжтойг нь хэрэгжүүлж эхэлсэн ба 2023 оны 10 сараас хойш хогоо ангилж хаяж байна. Бидний ангилсан хог хаягдал болох хуванцар сав, хөнгөн цагаан лаазыг TML Plastic дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эд ханган нийлүүлэгч “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК-тай хамтран ажиллаж байна.

